



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Г “Багануур АЗЗА” ХК-ийн 7  
үнэт цаасыг бүртгэлд бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.7, Компанийн тухай хуулийн 11.1, 22.1 дүгээр зүйл, Хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 3.1 дэх заалт, Төрийн өмчийн хорооны 2011 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 437 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,072,597 ширхэг хувьцаанаас 2,500,790 /хоёр сая таван зуун мянга долоон зуун ер/ ширхэг энгийн хувьцааг “Багануур АЗЗА” ТӨХК-ийн нэр дээр тусгаарлан үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар/Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК/Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Багануур АЗЗА” ХК/Ц.Загдбазар/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН